



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 26/05

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.1, 59.4, 60.1 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Инновэйшн инвестмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 15:00 цагт /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 1 дүгээр хавсралтаар баталж, мэдээг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонин, олон нийтийн телевизийн мэдээгээр хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисс-т даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай. 3 дугаар хавсралтад заасан бичиг баримтыг үнэт цаасны компаниуд, мөн компанийн албан ёсны цахим хуудсаар болон хурал зохион байгуулах комисс, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар ердийн аргаар санал авах саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.
8. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж /<https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр болон Хувьцаа эзэмшигч өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Компанийн өөрийн байранд буюу Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, НМ төв, 8 давхар хаягт урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба санал авах сүүлийн хугацаа нь 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цаг байна.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Б.Энхболд, гишүүнээр О.Маралмаа, хурлыг зохион байгуулах комиссын нарийн бичгийн даргаар П.Мөнхтуяа нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын дарга А.Баттамир, тооллогын комиссын даргаар “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Харилцагчийн албаны захирал Б.Онон, тооллогын комиссын гишүүнээр “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Б.Хулан, М.Оюунсүвд нарыг тус тус томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус хүргүүлэх болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компанид хүргүүлэх, түүнтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Энхболд)-д даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (О.Маралмаа)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР